



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 285

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдан авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны албан ажлын хэрэгцээнд зориулан 142,000,000.00 (нэг зуун дөчин хоёр сая) төгрөгт багтаан 1 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001955

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн
235... дугаар тогтоолын хавсралт



**Эрчим хүчний зохицуулах хорооны
худалдан авах автомашины техникийн үзүүлэлт,
үнийн дээд хязгаар**

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын тоо 7, хөдөлгүүрийн багтаамж 2500-3000 cc	1	142,000,000.00	142,000,000.00
	Дүн		142,000,000.00 (нэг зуун дөчин хоёр сая)	142,000,000.00 (нэг зуун дөчин хоёр сая)